ТҮҮХИЙН СУДАЛГАА

НИРУН УЛСЫН (330-555 ОН) ЭМЧ НАР АНАГААХ УХААНЫ ГОЛ НОМЫГ БРАХМИ БИЧГИЙН СУДРААС СУРЧ БАЙСАН БАРИМТЫГ ТОДРУУЛАХ НЬ

Ш.Болд[1], Б.Гэрэлмаа[2], Д.Шагдарсүрэн[3]
[1]МАУА, [2]"Ач" АУИС, [3]ЭЗШУИС,
e-mail: boldshrv@gmail.com

Abstract

CLARIFYING THE FACT THAT THE DOCTORS OF NIRUN (330-555) LEARNED THE MAIN BOOK OF MEDICINE FROM THE BRAHMI SCRIPTURES

Bold.Sh[1], Gerelmaa.B[2], Shagdarsuren.D[3]
[1]Mongolian Academy of Medical Sciences, [2]"Ach" Medical University,
[3]Mongolian University of Pharmaceutical Sciences
E-mail: boldshrv@gmail.com

Inscriptions written in Mongolian Brahmi script on a stone found in 584 and 601 from Bugat, Arkhangai Province, and Khuis Tolgoi, Bulgan Province are proof that the Mongolians of Nirun Dynasty's era (Juan-Juan, 330-555 CE) had Brahmi script. At the same time, the medical books written by Taksik doctor Galeino, the book "Sog po sha stag can gyi rgyud" by a Mongolian doctor who visited Tibet during the reign of King Trisondetsen (742-798) of Tibet, as well as Mongolian doctor Nalashandir's book titled "rgas pa gso ba'i yan lag bcud kyi rgya mtsho" are proved by the translation from an Indian language into the Tibetan language.

In addition, it is reasonable to consider the fact that Mongolians learned medicine in Sanskrit from the time of the Nirun Dynasty period (330-555 CE), which was recorded by the Altai doctor of Upper Mongolia in his book in 1612.

Another proof of this is the medical books that Hamilton Bower bought from Kucha (Kuqa), Xinjiang in March 1890. These books were medical treatises related to medicinal ingredients in the Charaka and Sushruta Samhita of ancient Indian Ayurvedic medicine, dating to the late 5th or 6th century. Kucha was a region controlled by Nirun Dynasty in the 4th to 6th centuries. Therefore, it is possible to confirm that the classic books of Ayurvedic medicine were popular in the Nirun Dynasty and these books were learned and studied in Sanskrit. Except for the Mongolian Brahmi script of the Nirun Dynasty period, the Brahmi script of the Tibetan language created by Mongolian scholar, Toin Jambaldorji was identified. This Brahmi script is a later (1823) proof of the Mongolian Brahmi script of the Nirun Dynasty's time and is considered to be a witness to the fact that Mongolian medical scholars created their books in many languages and different scripts.

Keywords: Brahmi script, Nirun Dynasty, Ayurvedic medicine, Mongolian doctor

Оршил

Язгуурын Монголчуудын өвөг дээдэс, Нирун улсын (НТ 330-555 он) үеэс анагаах ухааныг чухамдаа санскрит хэлээр туурвисан судар номоос сурч байсан баримт сэжүүр олдож байна. Гэхдээ анагаах ухааны судар нь санскрит хэлээр брахми үсгээр байсан уу? Эсвэл монгол хэлээр брахми үсгээр байсан уу гэдгийг олон талаас нь нягталж батлах шаардлагатай. Одоогоор бидэнд олдоод байгаа баримтаас үзэхэд тэр үед санскрит хэлээр бичсэн Бурхан багшийн номлосон судар дандар, эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны ном судрууд язгуурын Монголчуудын дунд түгээмэл байсан тул номын утгыг ухаж мэдэхэд хялбар дөхөм байжээ.

17 дугаар зуунаас эхлэн Монголчууд анагаах ухааны гол судрыг төвөд хэлээр суралцаж эхэлсэн. Тухайн үед төвөд хэлээр гол судрыг сурч эзэмшиж байснаас утгыг нь шууд онож ухахад бэрх, хүчиртэй байв. Ялангуяа гүн ухаан, онол, оношилгоо, эмчилгээний аргыг утгачилан орчуулахад утга зохилдсон, тогтсон нэр томъёоны үгсийн сан дутмаг, монгол хэлний тулгуур тайлбар ном үгүй болохоор үл мэдэх харь хэлээр (төвөд хэлээр) дандарыг сурахад хялбар бус байжээ. Үүнийг Дээд Монголын Алтай эмч бээр “Ингэснээр анагаах ухааны утга нь худалдаачны эд таваар мэт хэрэгтэй, хэрэггүй зүйл хувь тэнцүү холилдож сайн муу, зөв буруу нь эс ялгагдах болжээ” [1] гэж онцлон тэмдэглэсэн байна.

Бид судалгааны явцад Нирун улсын (НТ 330-555 он) үеэс анагаах ухааныг санскрит хэлний судар дандараас суралцаж байсан гэснийг таамаглах хэд хэдэн баримтыг олж тогтоолоо.

Нэг. Эхний баталгаа нь Дээд Монголын Алтайн эмчийн 1612 онд бичсэн анагаах ухааны номонд дурдсан Монголчууд санскрит хэлээр анагаах ухааныг сурч байсан баримт юм. Тэрбээр “Язгуурын үндэс”-ийн тайлбар номондоо: “Монгол үндэстэн анагаах ухааныг чухамдаа санскрит хэлний дандараас сурч байсан юм. Тэр үед санскрит хэлний “Чарагийн найман аймаг”, “Таван их бумтын аймаг”, “Буман анагаах засал” тэргүүтэн эртний өв хөрөнгө төгөлдөр байсан тул ухаж мэдэхэд хялбар дөхөм, ялангуяа эртний Монгол үндэстэнд “Ра” хэмээх дууны ухааны (үг найруулах, утгыг урлах-хэл шинжлэлийн онол) сургаал байсан тул хүчирддэггүй байжээ” [2] хэмээсэн байна. Энэ нь Монголчууд төвөд хэлээр бичсэн “Анагаах ухааны дөрвөн үндэс”-т суралцахаасаа хол өмнө нь санскрит хэлээр бичсэн эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны номуудыг үзэж судалж байсан томоохон баталгаа юм.

Алтай эмч өөрөө 1554 онд төрсөн. Тиймээс түүний төрсөн онооор нь баримжаалан Монголчууд төвөд хэлээр анагаах ухааны номыг сурч эхлэхээс өмнө нь санскрит хэлээр сурч байсан үеийг ойролцоогоор тогтоож болно. Монголчууд санскрит хэлээр анагаах ухааны номыг судалсан үе нь Буддын шашны дэлгэрэлттэй шууд холбоотой юм. Монгол оронд Буддын шашин гурван удаа дэлгэрсэн хэмээн өгүүлдэг.

1. Хүннү гүрнээс Кидан улс хүртэлх буюу НТӨ II - НТ XII зуун. Энэтхэгээс шууд болон Дундад Азиар дамжин их, бага хөлгөний урсгалууд дэлгэрсэн үе. Энэ үеийг Буддын шашны түрүү дэлгэрлийн үе гэдэг.
2. Чингис хаанаас Тогоонтөмөр хаан хүртэлх их хаадын үед Төвөдийн Сажава хийгээд Гармавагийн чиглэлүүд дэлгэрсэн. Энэ үе нь XIII-XIV зууныг хамардаг. Буддын шашны дунд үеийн дэлгэрэлт юм.
3. Богд Зонховын шашин дэлгэрч хөгжсөн буюу XVI-XX зууныг Буддын шашны дэлгэрэлтийн гуравдугаар үе хэмээдэг.

Буддын шашны хоёр болон гуравдугаар дэлгэрэлтийн үе нь Төвөдийн буддын шашны урсгал, хэл, соёл хүчтэй байсан учраас санскрит хэлээр анагаах ухааны ном судлах боломж харьцангуй бага, харин түрүү дэлгэрэлтийн үе нь ихээхэн анхаарал татаж бидний таамаглалыг батлах баримтууд цөөнгүй байна.

Буддын шашин Хүннү, Сяньби (НТӨ II – НТ IV зуун) улсын үед нийгмийн дээд давхрагын хүрээнд дэлгэрч байсан. Түрэг (VI-VIII зуун), Уйгар (VIII-IX зуун), Киданы (X-XII зуун) үед хэдийгээр Буддын шашин дэлгэрч байсан ч бөөгийн шашны уламжлал хадгалагдаж байв. Мөн бичиг үсгийн хувьд Түрэгүүд руни бичиг, Уйгарууд согд, уйгар бичиг, Киданчууд ханз үсгэнд суурилсан их, цагаан толгой бүхий бага бичигтэй байв.

Гэтэл Буддын шашны түрүү дэлгэрлийн дунд үед, Нирун улс (НТ 330-555 он)-д Буддын шашин хүчтэй дэлгэрч санскрит хэл, брахми үсэг хэрэглээд нэвтэрч, Буддын шашин төрийн хэмжээнд өргөмжлөгдсөн.


Нирун улсын хаан Буддын шашны судар, их, бага ухааныг тайлж эзэмшсэн лам Дармаприяг төрийн багшаар өргөмжлөн 3000 өрх соёрхжээ [3]. Жужан нарын дунд Буддын шашин хүчтэй дэлгэрч байсан болохоор Өрнө, Дорно зүгт зорчих лам нар Жужаны нутгаар дайран өнгөрдөг, ном судар түгээдэг байв. Тухайлбал, 475 онд Өмнөд Ци улсын лам Фа Сянь (424-498) Жужаны нутгийг

дамжин Хотон хүрээд буцахдаа, өөрийн аялсан баруун зүгийн Уми орноос Бурхан багшийн нэг шүд, шарилын зүйл, ном судар, алтаар давтан хийсэн бурхны хөрөг зэргийг олж авчээ [4] гэсэн баримтууд байна. Энэ үеэс Нируны Монголчууд брахми үсэгт үндэслэн монгол брахми бичгийг зохиожээ. Гэхдээ энэхүү бичгээр бичсэн гар бичмэл, хусны үйс болон бусад хэвлэлийн материал дээрх үсэг, бичгийн дурсгал одоогоор олдоогүй байна.

Харин чулуун дээр бичсэн монгол брахми бичгийн дурсгал бидний үед уламжлагдан иржээ. Үүний гол баталгаа нь Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Д.Цэнд ахлагчтай анги 1967 онд Булган аймгийн Могод сумын нутаг, Хүйс толгой хэмээх газраас үл мэдэгдэх бичээс бүхий гурван чулуун хөшөө олсон. 1972 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү энэхүү чулуун хөшөө дээрх бичгийг баримтжуулж, эртний брахми бичиг болохыг тогтоожээ [5].

Дараа нь судлаач Диетер Мауэ 2014 онд Хүйс толгойн бичээс бол монгол хэлээр, брахми бичгээр бичсэн хөшөө байна гэдгийг баталсан. Мөн эрдэмтэн Александр Вовин, Диетер Мауэгийн галигийг үндэслээд “Энэ бол өвөг монгол бичиг, үсэг мөн” гэдгийг зарим хэл зүйн элементээр нотолжээ [6].

Германы монголч эрдэмтэн Солонгод Л.Хурцбаатар уг чулууны бичээсийг тайлж уншсан байна. Энэхүү монгол брахми бичгийн дурсгал нь НТ 601 оны үед хамаарагдана. Нийт 11 мөр, эртний монгол хэлээр брахми үсгийн 215 тэмдэгтээр бичсэн 100 үгээс бүрдсэн. Гэхдээ Хүйс толгойн бичээс нь 601 онд хамаарагдах боловч түүнээс өмнө Архангай аймгаас олдсон Бугатын брахми үсгээр бичигдсэн хөшөө нь 584 онд хамаарагдана. Уг чулуун хөшөөний бичээс нь Монгол үндэстэн нэн эртнээс үсэг, бичигтэй байсны нотолгоо, шашин шүтлэг, тахилга, зан үйлийн тухай ховор баримт юм.



Хүйс толгойн бичээс-1

(2018 оны 8 дугаар сарын 8-нд Солонгод Л.Хурцбаатарын буулгасан сүүдэр зураг)

Эртний монгол хэлээр брахми үсгээр бичсэн энэхүү дурсгалтай цаг хугацаа нь тун ойрхон санскрит хэлээр брахми үсгээр хусны үйсэн дээр бичсэн эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны номын хуудсуудыг Британийн армийн дэслэгч Хамилтон Бауэр олсон байна. Хамилтон Бауэр 1890 оны 3 дугаар сарын эхээр Шинжааны Кучад тусгай үүрэг гүйцэтгэхээр иржээ. Ирсэн даруйдаа Куча орчимд хуарангаа байгуулсан байна. Гуравдугаар сарын 2-ноос 3-нд шилжих шөнө нэгэн хүн майханд нь ирж, хуучин гар бичмэл, эд өлгийн зүйлсээ худалдан авахыг санал болгов. Бауэр тэднийг худалдаж авчээ. Энэ үеэс эхлэн эдгээр гар бичмэлийг уншиж судлах боломж нээгдэж улмаар Бауэрийн гар бичмэл хэмээн түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Бауэрийн гар бичмэл нь 5 дугаар зууны сүүл эсвэл 6 дугаар зууны эхний үеийн Гупта брахми үсгийн санскрит хэлний гар бичмэл бүтээлүүд юм [7].

Куча хотоос олдсон эдгээр гар бичмэлүүд нь эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиол (33 навч) болон бусад хэд хэдэн зохиол (23 навч), нийтдээ 7 зохиол багтдаг. Анагаах ухааны зохиолыг нь Чарака, Шушрута самхитагийн эм найрлагатай холбоотой бичвэрүүд болон Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны эртний бүтээлийн хэсгүүд хэмээн үздэг. Одоо Бауэрийн гар бичмэлүүдийн эх нь Оксфордийн Их сургуулийн Бодлейн номын санд хадгалагдаж байна.



Бауэрийн гар бичмэлийн нэгэн хуудас [8]
(Брахми үсгээр санскрит хэлээр)

Бауэрийн гар бичмэлүүдээс хэд хэдэн гаргалагаа хийж болохоор байна.

1. Хойд Торгоны зам нь Тэнгэр уул (Тяньшань)-аас хойд зүгт Таримын сав газрыг тойрч, 3 замаар дайран өнгөрдөг. Нэг нь Такламакан цөлийн хойд хэсэг, нөгөө нь өмнөд хэсэг, дунд тал нь Лопнор мужаар эхний хоёр замыг холбодог. Хойд Таримын зам нь Кашгараас Аксу, Куча, Корлагаар дайран Төмөр хаалганы даваагаар дамжин цааш үргэлжилнэ. Тиймээс Таримын сав газар нь Жужан улсын хувьд стратегийн маш чухал ач холбогдолтой, хяналтандаа байлгадаг газар байв.
2. Өвөг Монголчуудын дунд Буддын шашин Таримын сав газраар дамжин тархсан. Тиймээс Таримын сав газар, Дунхуань, Турфан, Хар хот (Karasahr), Куча нь Монголын соёл, бичиг үсэг, шашин номтой шууд холбоотой газрууд юм. Тиймээс Хамилтон Бауэрийн 1890 онд олсон санскрит хэлээр брахми үсгээр хусны үйсэн дээр бичсэн анагаах ухааны номууд тухайн үедээ Нирун улсын Монголчуудын дунд тархаж байжээ гэж үзэх бүрэн боломжтой хэмээн таамаглаж байна. Үүнийг Дээд Монголын Алтай эмч 1612 онд бичсэн анагаах ухааны номондоо: “Монголчууд санскрит хэлээр анагаах ухааныг сурч байсан” хэмээн баталгаажуулан тэмдэглэжээ гэж үзэх үндэстэй юм.
3. Жужанчууд монгол брахми бичиг зохиохоос өмнө эхлээд санскрит брахми үсгээр бичсэн бүтээлүүдтэй санскрит хэлээр уншин танилцаж, судалж байв. Хожим нь санскрит бус брахми үсэг тухайлбал, монгол брахми үсэг бичиг бий болжээ.
4. Алтайн эмчийн “Ялангуяа эртний Монгол үндэстэнд “Ра” хэмээх дууны ухааны (үг найруулах, утгыг урлах, хэл шинжлэлийн онол) сургаал байсан тул хүчирддэггүй байжээ” гэж бичсэнийг анзааралгүй орхиж болохгүй юм. “Брахми” гэсэн дуун ухааныг “Ра” хэмээх дууны ухаан гэж нэрлэсэн байх гэж таамаглаж байна.

Хоёр. Төвөдийн Соронзонгомбо хаан (НТ 625-650 он) анагаах ухааны уулзалтыг VII зуунд Төвөдөд зохион байгуулсан. Уг уулзалтанд Энэтхэг, Хятадын эмч нар болон Дагсиг (stag zigs)-аас Галэйной (Galesntos) эмч ирсэн бөгөөд тэд өөр өөрсдийн орны анагаах ухааны ном, гарын авлагуудыг Төвөдийн хаанд танилцуулжээ. Дагсиг буюу Барс ирвэсийн орны хүн ам бол Монгол язгууртай, эхлээд Буддын шашин шүтэж байгаад хожим нь Исламын шашинтай болсон. Дагсигийг Монгол гаралтай гэдгийн Зава Дамдин гавж “Хор Монгол дор алдаршсан их орон Хятад, Тангад, Төвөд бүгдийн хойд зүгт олон буй. Ялангуяа Хор (hor) ба Согбу (sog po) хийгээд өчигдөр, өнөөдөр Чагар (cha dkar)-т алдаршсан тэргүүтэн олон буй ч нийтэд нь Хорын улс хэмээн нэгэнд өгүүлсэн нь мөн болой хэмээн зарлигласан тул Дагсиг, Согбу луугаа язгуур яс нэгэн юм” гэж “Алтан дэвтэр”-тээ тэмдэглэсэн байна [9]. Тиймээс Галэйной (Galesnos) бол монгол гаралтай эмч юм. Үүний өөр нэгэн баталгаа нь тэрбээр Төвөдийн хааны эмчээр Төвөдөд үлдэн гэрлэж 3 хүүтэй

болсон. Том хүү нь Лхасын ойролцоо байдаг Зандод гэдэг газар луу явж Вижи тэргүүтэн удмыг бий болгосон. Дунд хүү нь Төвөдийн өмнө зүгийн халуун бүс рүү явж (Балба-Энэтхэгийн хил хавьцаа) сайн эмчийн удмыг үүсгэсэн. Харин бага хүү нь аавынхаа эрдмийг өвлөн авч “Согбу мамба” Монгол эмч хэмээн нийтэд алдаршжээ [10] гэж бичсэнд оршино. Мөн Төвөдөд очсон 3 орны эмч нар хамтран ажиллаж өөрсдийн анагаах ухааны номууд дээр тулгуурлан хэд хэдэн ном бичжээ. Энэ талаар Японы эрдэмтэн профессор Tsuneo Namba “Дагсигаас очсон Галэйной нар Төвөдөд уригдан ирж өөр өөрийн орноосоо авчирсан анагаах ухааны номуудыг төвөд хэлээр орчуулсан” [11] хэмээн бичсэн байдаг. Тиймээс Дагсигаас ирсэн Галэйной эмчийн авчирсан ном монгол хэлээр брахми үсгээр бичсэн, руни бичгээр бичсэн эсвэл санскрит хэлээр брахми үсгээр бичсэн байсан уу гэдгийг тогтоох нь чухал асуудал юм.

Гурав. Төвөдийн Дисрондэзан (742-798) хааны үе Энэтхэг, Хятад, Кашмир, Монгол, Түгү, Долбо, Балба, Гарлог зэрэг орны эмч нар Төвөдөд өөд болсон ба тэд өөр, өөрсдийн бичсэн, эмхэтгэсэн анагаах ухааны судар номоо төвөд хэлээр орчуулсан. Жишээлбэл: Энэтхэгийн эмч Шантигаравын орчуулсан Буддагийн номлосон “Рашааны том, жижиг бадар аяга”, “Рашаант бумбын охь шим”, Нагаржунайн номлосон “Таван шашдир”, Дарь эхийн номлосон “Зуун мянган эмийн ургамал”, Кашмир эмчийн эмхэтгэн, орчуулсан “Заслын эрхэст харанхуйг арилган үйлдэгч зул”, “Заслын есөн шашдир”, Дагсиг орны эмчийн “Толгойн өвчнийг засах сувдын аймгийн найман үндсийн тайлбар”, ”Судлыг анагаах увдис их, бага галбирваасан мод”, “Хурмалыг засах арга амин эрдэнийн хүрд”, “Монголын эм найрлагын үндэс” (Sog po sha stag can gyi rgyud), Түрэгийн хааны “Хорыг анагааж, үхлийг амилуулах найрлага” зэргийг энэтхэг хэлнээс төвөд хэлэнд орчуулсан хэмээжээ [12]. Дисрондэзан хааны үед Төвөдөд өөд болсон 9 орны эмч нарын дотор Монголоос очсон Налашандир эмч ”Настайчуудыг анагаах гишүүн шимийн далай” гэдэг ном авч очсон бөгөөд уг ном мөн л монгол хэлээр брахми үсгээр бичсэн ном уу эсвэл руни бичгээр бичсэн ном байсан уу гэдэг нь анхаарал татаж байна.

Дээд Монголын Алтай эмчийн анагаах ухааныг монголчууд санскрит хэлээр сурч байсан баримт, Дагсигийн Галэйной эмчийн Төвөдийн хаанд өргөсөн анагаах ухааны ном, “Монголын эм найрлагын үндэс”, Монгол эмч Налашандирын ”Настайчуудыг анагаах гишүүн шимийн далай” номыг энэтхэг хэлнээс төвөд хэлээр орчуулсан баримт, Архангай аймгийн Бугат, Булган аймгийн Хүйс толгойгоос олдсон 584, 601 оны үеийн монгол хэлээр брахми үсгээр чулуун дээр бичсэн бичээсийн хооронд дахь учир зүйн холбоосыг тогтоосноор Нирун улсын сүүлч, Түрэгийн хаант улсын эхний үеийн Монголын анагаах ухааны нэн эртний бичиг үсгийн дурсгалыг тодруулах боломж нээгдэх юм.

Дөрөв. Тойн Жамбалдоржийн зохиосон төвөд брахми үсэг

Найман тойн Жамбалдорж XIII жарны усан хулгана жил, 1792 онд Найман хошууны есдүгээр засаг төрийн дархан ван, Чингис хааны угсаа болох эцэг Балчог хийгээд эх Балмо хоёрын хоёрдугаар хөвгүүн болж төрсөн бөгөөд эцэг, эх нь түүнд Жамбалдорж гэдэг нэр хайрлажээ. Жамбалдорж буддын шашины их 5 ухаанд нэвтэрсэн, монгол, манж, хятад, төвөд хэлийг чөлөөтэй эзэмшсэн, өөрийн сүмийн сахил санваар, хурал номын дэг жаяг, өргөл магтаал зэргийн талаар багагүй бүтээл туурвисан мэдээ байдаг. Эцэг Балчог нь Найман хошууны есдүгээр засаг төрийн дархан ван хүн учраас сахил авсан Жамбалдоржийг тойн хэмээн нэрлэх болсон. Гэхдээ Төвөд судлаачдын бүтээлд сахилын нэрээр нь гэнэн Жамбалдорж хэмээн алдаршуулдаг.


Тойн Жамбалдоржийн бичсэн уламжлалт анагаах ухааны эм судлалтай холбоотой 2 гол ном бий. Эхний ном нь “Анагаан үйлдэх рашааныг эндүүрэл үгүй танин мэдэх, урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай” (gso byed bdud rtsi’i ‘khrul med ngos ‘dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so) гэсэн модон барын төвөд судар бий. Хоёрдох ном нь эхний номондоо орсон эрдэс, эрдэнэ, ургамал, амьтны гаралтай эмийн зураг, хануур, хатгуур, төөнүүрийн багаж, сүвийн байрлалыг үзүүлсэн тэг зураг, “Язгуурын үндэс”-ийн модны зураг сэлтийг багтаасан ”Хиргүй болор эрхт өгүүлсэн эмийн түнбэ гайхамшигт үзэсгэлэнт нүдний чимэг” (товчоор Бага үзэсгэлэнт нүдэн чимэг гэдэг) бар дүрс бүхий ном юм. Энэ хоёр зохиолыг 1817-1851 оны хооронд бичсэн бөгөөд гадаад, дотоодын

эрдэмтэд өнгөрсөн зууны дунд үеэс судалсаар өнөөг хүрчээ. “Бага үзэсгэлэнт нүдэн чимэг” номонд үл мэдэх үсгээр бичсэн 4 мөрт байдаг [13]. Эдгээр үгийг тайлж уншин, тусгайлан судалсан судалгааны ажил одоогоор алга байна. Энэ бичвэрийн үсгийг сайтар шинжилж үзвээс номын ихэс дээдэс хоорондоо харилцдаг, нийтэд хүртээл болголгүй зөвхөн өөрсдөө мэддэг кодолсон үсгүүд юм байна.

Ийм үсгийг нууц тарнийн ёсонд мэргэжсэн номын мэргэд, хутагт хувилгаадууд зохиодог. Үүний тод жишээ бол Өндөр гэгээн Занабазар юм. Өндөр гэгээн соёмбо (Өөрөө бүтсэн үсэг) үсгээ 1686 онд зохиосон. Тойн Жамбалдорж нь нийтдээ 2 боть сүмбумыг Ишдондовдамбийжалцан гэсэн сахилын нэрээрээ барт гаргажээ. Эдгээр бүтээлүүд 785 хуудастай, бүгд нууц тарины ёсны судрууд болно [14].


Нууц тарнийн ёсонд мэргэжсэн мэргэд гадаад орчны янз бүрийн хэлбэрийн мэдээллийг хоромхон хугацаанд боловсруулах чадвартай болдог бөгөөд энэхүү чадвараа ашиглан янз бүрийн шид, увдис үзүүлдэгийн нэгэн жишээ нь Жамбалдорж тойны бүтээсэн үсэг юм.

Гэхдээ үсгийн тэгүүд нь төвөд үсэгтэй тохирч байна. Богино, босоо зураас нь үе тусгаарлах, гийгүүлэгчийн дээрх тэмдэгтүүд нь төвөд эгшиг юм. Энэ үсэг нь ямар нэг зүйлийг хамгаалах, далдлах зорилготой төвөд хэлний тусгай үсэг буюу тойн Жамбалдоржийн брахми үсэгт суурилан зохиосон үсэг байж болох юм. Чухамдаа төвөд хэлээр брахми үсгээр бичсэн 4 мөрт шүлэг гэж хэлэхээр байна. Брахми үсгийн хувьд Хойд Энэтхэгт дэлгэрсэн брахми цагаан толгойгоос гаралтай бус харин Өмнөд Энэтхэгт тархсан брахми үсэгт суурилсан болов уу? Ингэж таамаглан хэлэх үндэслэл байна. Үүнд:




Тойн Жамбалдоржийн “Бага үзэсгэлэнт нүдэн чимэг” ном доторх үл мэдэх үсгээр бичсэн 4 мөрт

1. Бид энэхүү үсгийн тэг, зурлага, хэлбэрийг ижил төстэй байж болох брахми үсгийн олон янзын бичлэгтэй харьцуулан үзээд Өмнөд Энэтхэгийн Паллава үсгээс (Pallava script or Pallava Grantha) гаралтай Мон үсгийн (Mon script) цагаан толгойтой тун төстэй гэж үзэв. Паллава үсэг нь брахми үсэг бөгөөд 4 дүгээр зуунаас Өмнөд Энэтхэгийн Паллава гүрний нэрээр Паллава үсэг гэж нэрлэгдсэн. Зүүн өмнөд Азийн орнуудад ихэд дэлгэрсэн үсэг.
2. Мон үсэг (Mon script)-ээр бичсэн Буддын шашны Теравада (Бага хөлгөн) урсгалын олон зуун судар номууд бичигджээ. Тухайлбал Бирми, Мьямарын зүүн өмнөд хэсэг, Тайландын хойд хэсэгт их байдаг. Эдгээр судар номууд Зүүн өмнөд Азийн худалдааны замаар дамжин Монголд орж ирэх боломжтой юм.
3. Төвөд үсэг, ялангуяа толгойтой үсэг (Uchen script) нь Гүпта үсэг (Gupta script)-ээс гаралтай гэж үздэг бөгөөд Гүпта үсэг нь брахми үсэг (Brahmi script)-ээс үүсчээ. Тиймээс тойн Жамбалдорж ямар нэг ургамлын амт, чадлыг далдлах зорилгоор төвөд хэлний тусгай үсгийг брахми үсэгт тулгуурлан зохион бичжээ. Гэхдээ нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд Брахми үсгээс (Pallava script) үүсэлтэй Мон үсэг (Mon script)-тэй төстэй үсгийн зөвхөн тэг, хэлбэр дүрсийг нь ашиглан, төвөд үсгийн авиа зүй, дуудлага, тийн ялгал, угтвар, дагавар, толгойтой, зүүлтэд үсэг зэрэг хэлний дүрэмтэй бүрэн зохицуулж найруулжээ.



“Зураач гуай” гэж алдаршсан А.Ламжавын
Тойн Жамбалдоржийн “Бага үзэсгэлэнт нүдэн чимэг” номыг хуулан зурсан
сударт буй брахми үсгээр бичсэн 4 мөртийн бичээс [15]



Мьянмар улсын Мандалай дахь Кутодав сүмд хадгалагдаж буй Мон-Бирми үсгээр бичсэн
Буддын шашны “Гурван аймаг савын ном”-ын нэгэн хуудас [16]

Бид тойн Жамбалдоржийн “Бага үзэсгэлэнт нүдэн чимэг” ном доторх брахми үсгээр зохиомжлон бичсэн 4 мөрт шүлгийг төвөд үсгийн латин галигт буулгав.



Жамбалдоржийн брахми үсгээр зохиомжлон бичсэн
4 мөрт шүлгийг төвөд үсгийн латин галиг

Дараа нь уг 4 мөрт шүлгийг төвөдөөс монгол хэлээр дараах байдлаар орчууллаа.

bu ram shing kun snyin po ci yang med
Бурмын мод бүгдэд шим огт үгүй

dga’ bar bya ba’i ro ni nang na ‘dug
Баясгалант амт нь дотор талд буй

shun pa zos pa’i mis ni bur ma ro
Хальсыг нь идсэн хүмүүн бээр

zhim po rnyed par nus pa ma yin no
Бурмын сайн амтыг нь олж чадахгүй

гэж орчуулагдаж байна. Уг бичвэрийн гол санаа нь уламжлалт анагаах ухаанд маш өргөн хэрэглэдэг эмт бодис болох бурмын мод бүхэн шимтэй, үр тэжээллэг, ашигтай байдаггүй. Мод модны дундаас бурмын мод хамгийн шимтэй гэдэг нь эргэлзээтэй юм. Хамгийн чухал амт нь дотор талдаа буй. Өөрөөр хэлбэл амтын чадал нь дотроо оршино.

Хальсыг идсэн хүмүүнд амт үгүй гэдэг нь хальсыг нь эмэнд хэрэглэж болохгүй. Учир нь хальсанд нь амтын чадал үгүй. Амтын чадал үгүй бол эмийн үйлдэл гарахгүй. Тиймээс сайн амт буюу амтын чадал байхгүй бол гэмийг эмчилж чадахгүй болно гэсэн санаа юм. Монголын уламжлалт анагаах ухаанд эмийн чадалд амтын чадал, мөн чанарын чадал лугаа хоёр буй. Үүнийг бас жирийн, ялгавартай гэж хоёр хуваадаг. Юуны өмнө амт, чадал, эрдэм, гурвыг сайтар танин мэдэх хэрэгтэй байдаг. Энэ санааг далд утгаар илэрхийлэх зорилгоор тойн Жамбалдорж брахми үсэгт суурилан төвөд хэлний дүрэмд нийцүүлэн шинэ үсэг зохион өөрийн бүтээлдээ бичиж үлдээжээ.

Дүгнэлт

1. Дээд Монголын Алтай эмчийн бүтээлдээ тэмдэглэсэн анагаах ухааныг монголчууд санскрит хэлээр сурч байсан 1612 оны баримтын эрт үеийн цаг хугацааг Нирун улсын (НТ 330-555 он) үеэс гэж үзэх үндэслэлтэй юм.
2. Нирун улсын хаан Буддын шашны судар, их, бага ухааныг тайлж эзэмшсэн лам Дармаприяг төрийн багшаар өргөмжлөн 3000 өрх соёрхсон, Өрнө, Дорно зүгт зорчих лам нар Жужаны нутгаар дайран өнгөрдөг, ном судар түгээсэн баримтууд, Хамилтон Бауэр 1890 оны 3 дугаар сард Шинжааны Кучаагаас худалдаж авсан 5 дугаар зууны сүүл эсвэл 6 дугаар зуунд хамаарагдах эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны Чарака, Шушрута самхитагийн эм найрлагатай холбоотой анагаах ухааны зохиолууд нь Нирун улсад Аюурведийн анагаах ухааны сонгодог судар номууд дэлгэрч, уг бүтээлүүдийг санскрит хэлээр сурч, судалж байсныг гэрчлэх баримт гэж үзэв. Үүнийг Дээд Монголын Алтайн эмч 1612 онд бичсэн “Язгуурын үндэс”-ийн тайлбар номондоо: “Монгол үндэстэн анагаах ухааныг чухамдаа санскрит хэлний дандараас сурч байсан юм. Тэр үед санскрит хэлний “Чарагийн найман аймаг”, “Таван их бумтын аймаг”, “Буман анагаах засал” тэргүүтэн эртний өв хөрөнгө төгөлдөр байсан тул ухаж мэдэхэд хялбар дөхөм байсан хэмээн бичсэн нь давхар баталгаа болж байна.
3. Архангай аймгийн Бугат, Булган аймгийн Хүйс толгойгоос олдсон 584, 601 оны үеийн монгол хэлээр брахми үсгээр чулуун дээр бичсэн бичээс нь Нируны үеийн язгуурын Монголчууд брахим үсэг бүхий бичигтэй байсныг нотлоод зогсохгүй, Дагсигийн эмч Галэйнойн бичсэн анагаах ухааны ном, Төвөдийн Дисрондэзан (742-798) хааны үед Төвөдөд очсон монгол эмчийн “Монголын эм найрлагын үндэс” ном, Монгол эмч Налашандирын ”Настайчуудыг анагаах гишүүн, шимийн далай” номыг энэтхэг хэлнээс төвөд хэлээр орчуулсан гэсэн баримтаар нотлогдож байна.
4. Тойн Жамбалдоржийн зохиосон төвөд хэлний брахми үсэг нь Монголчууд брахми үсгийг өнө эртнээс (584, 601 он) хэрэглэж байсан хожмын (1823 он) баталгаа бөгөөд Монголын анагаах ухааны мэргэд олон хэлээр, олон янзын бичиг үсгээр бүтээлээ туурвиж байсныг гэрч хэмээн үзэв.

Ашигласан хэвлэл

1. Монгол уламжлалт анагаах ухааны гол шаштирын язгуур үндсийн далд утгын тайлбар, мод тавих ёс. Орчуулж, эмхэтгэсэн Ш.Болд. УБ, 1997, х.32
2. Монгол уламжлалт анагаах ухааны гол шаштирын язгуур үндсийн далд утгын тайлбар, мод тавих ёс. Орчуулж, эмхэтгэсэн Ш.Болд. УБ, 1997, х.32
3. Сүхбаатар Г. Монгол Нирун улс (330-555). УБ, ШУА-ийн хэвлэлийн “Эрдэм” пүүс. 1992, х.96
4. Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ, 2003, х.331

5. Хүйс толгойн бичээсийг төрийн ордонд залав. https://ikon.mn/n/1qd7
6. Гансаруул Д. Хүйс толгойн бичээсийг тайлж, уншсан эрдэмтэн л.хурцбаатар: уг бичээсийг аавынхаа гэрээс, багшийнхаа захиасыг санан санан байж тайлж уншсан. Солонгод овогт Л.Хурцбаатартай хийсэн ярилцлага. https://dnn.mn/
7. Wujastyk D. The Roots of Ayurveda: Selections from Sanskrit Medical Writings. Penguin Books India, 1998, p.196-197
8. The Bower Manuscript. Edited by A.F.Rudolf Hoernle Ph.D., Parts III to VII. Calcutta, 1897
9. Зава Дамдин. Гайхамшигт алтан дэвтэр. Орчуулж, тайлбар зүүлт хийсэн төвөдөч Хомоолын Түмэнбаяр. Улаанбаатар, 2021, х.31
10. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2011, х.122
11. Tsuneo Namba. An Overview of Tibetan Traditional Medicine from the Comparative Ethnopharmacology. Tokyo, 1993
12. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2011, х.66
13. Тойн Жамбалдорж. dri med shel phreng nas bshad pa'i sman gyi 'khrungs dpe mdzas mtshar mig rgyan. Модон барын төвөд судар.
14. Эрдэнэбаяр. "Найман тойн Жамбалдоржийн намтар, судлал." ӨМ-ын АХХ, х.17
15. Ламжав А. gzhan yang bya bar mdo las gnas sman ngos 'dzin 'khrul po chis snang banyegs thabs sman gyi 'khrungs dis mdzes tshad mig rgyan ces bya ba bzhug so. Төвөдийн толгойгүй шараар бичсэн гар бичмэл, өнгөт судар.
16. J Marshall. Alamy Stock Photo. Mandalay, Burma